## III. ШИНЭ АЖИЛ

**МХТ өргөндөлгөрвөл ажилгүйдэл газар авах уу?**

Жэрэми Рифкин МХТ-ийн нөлөөгөөр хөдөлмөрийн бүтээмж өсөх нь ажлын байранд дараахь хоёр аргаар нөлөө үзүүлдэг гэж үзжээ[1]. Нэгдүгээрт, техник технологи нь цаг хэмнэх төдийгүй ажил хөнгөвчилдөг тул компаниуд ажилчдаа бөөнөөр нь халах боломж олгоно. Хоёрдугаарт, ажлаасаа чөлөөлөгдөөгүй хэсэг ажилчид нь илүү цагаар ажиллах хэрэг гарна. Компаниудын хувьд ажиллах хүч бага байх нь эрүүл мэндийн даатгал зэрэг нийгмийн халамжинд бага хөрөнгө зарцуулах үр өгөөжтэй.

Үйлдвэрлэлийн хувьсгалын түүхээс харвал ажиллах хүч хэзээ ч үгүй болохгүй бөгөөд зөвхөн тодорхой зарим төрлийн хэсэг нь үгүй болно. Петр Дракер ямар төрлийн ажил үгүй болж болох талаар санал бодлоо илэрхийлжээ. Тэрээр "мэдээллийн хувьсгал нь тоо томшгүй олон салбаруудад уламжлалт үйл ажиллагаануудыг автоматжуулсан"[2] гэж үздэг. Үйлдвэрлэлийн хувьсгал нь нэхэж, сүлжихийг механикжуулсан шиг мэдээллийн хувьсгал нь роботуудын тусламжтайгаар автоматжуулах болно. Үүний үндсэн зарчим нь өмнөх цаг үеүдэд гарч байсан болонтехнологийнхувьсгалаас нэг их ялгаагүй юм.

Ажлын байрууд мөнхөд байсаар байх бөгөөд харин зөвхөн ажлын байрны хэрэгцээтэй салбар, чиглэл л өөрчлөгдөнө.

**Ямар ажлынбайр шаардагдах вэ?**

Мэдээллийн эринд шинэ ажлын байрууд ихээр бий болно. Уламжлалт үйлвэрлэлүүдэд (хуучин ажилчид солигдоно), МХТ-ийн шинэ үйлчилгээ, агуулга боловсруулагч (мэдээллийн ажлын байр), дэд бүтцийг бүрдүүлэгч болон мэдээллийн эдийн засгийн салбарт (мэдээллийн менежерүүд) болонэдгээртэй холбоотой бусад салбаруудад олоншинэ ажлынбайр бий болно.

Хамгийн эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжилтнүүд нь мэдээллийн технологийн (МТ) мэргэжилтнүүд юм. 1999 оны АНУ-ын Худалдааны танхимаас явуулсан судалгаагаар "сүүлийн 15 гаруй жилийн турш компьютерийн инженерүүд, программистууд, системийн аналистууд зэрэг МТ-ийн салбарын мэргэжилтнүүд эрэлт ихтэй байсан. Сүүлийн жилүүдэд компьютерийн судлаач болон системийн анализийн мэргэжилтнүүдийн хэрэгцээний хувь эрс өслөө"[3] гэсэн дүгнэлт гарчээ. Өнөөгийн эдийн засгийн уналтын үед уг эрэлтийн хандлага бараг өөрчлөгдөөгүй харин бага зэрэг удааширсанбайна.

Гэхдээ энэ нь зөвхөн тус салбарынхан эрэлттэй байна гэсэн үг биш. Инженер, хуульч, эрдэмтэн, профессор, гүйцэтгэх албан тушаалтан, сэтгүүлч, зөвлөгч зэрэг бусад мэдээлэл боловсруулалтын салбарт ажилладаг "оюун ухааны салбар" буюу Роберт Рэйчийн нэрлэснээр "амьдралын утга учир мөн чанарыг судлаачид" даяарчилсан эдийн засагт өөрсдийн оюуны үйлчилгээгээ борлуулах өргөн боломжтой болно. Мэдээлэл үргэлж амин чухал байдаг эдийн засгийн салбарт мэдээлэл, мэдлэгт дүн шинжилгээ хийгчид буюу "мэдлэгийн ажилтнууд" элит давхаргад багтах гэнэ.

**Жишээ 7. Шинэ ажиллах хүч**

...Мэдээлэл, мэдлэгийн салбарын ажилтнууд нь шинэ хөрөнгөтнүүд болж байна. Мэдлэг бол аливаа нөөцийн түлхүүр болсон байгаа тул оюуны хөдөлмөр эрхлэгчид үйлдвэрлэлийг удирдаж байна гэсэнүг юм...

Үр ашигтай мэдлэг нь нарийн төвөгтэй. Мэдлэгийн салбарын ажилчид тэр салбартаа хэр зэрэг мэргэшинэ төдий чинээ мэдлэг нь үр ашигтай байдаг. Иймээс тэдний мэдлэгийг нь нэгтгэн эцсийнбүтээгдэхүүнболгонгаргах байгууллага хэрэгтэй болдог байна...

Мэдээлэл, мэдлэгийн салбарын ажилтнууд нь "байнгын ажилтан" байхаасаа илүү төлбөрт үйлчилгээ үзүүлдэг "мэргэжилтнүүд" байхыг илүүд үздэг.

...Эрт дээр үеэс эмэгтэйчүүд нь хөдөлмөр эрхэлж ирсэн боловч тэдний хөдөлмөр эрчүүдийнхээс ялгаатай байсаар ирсэн. Эрчүүдийн ажил, эмэгтэйчүүдийн ажил гэж тус тусдаа байсан..Оюуны хөдөлмөр нь "хүйсээр ялгадаггүй" билээ. Учир шалтгаан нь феминист үзэл баримтлалын нөлөө дарамт биш харин үүнийг эрэгтэй, эмэгтэй хүн аль аль нь эрхлэх боломжтойд л байгаа юм.

Энэ салбар ын ажилтнуудад мэдээлэл боловсруулалтын салбарт ороход нь хэрэг болох албан ёсны мэдлэг боловсрол эзэмших, дараа нь өөрсдийн мэдлэгээ шаардлагатай түвшинд барьж байхынтулд насантурцдаа мэдлэгээ шинэчилж байх гэсэнхоёр үндсэнхэрэгцээ байдаг.

Хэдийгээр мэдлэгийн гол эх үүсвэр нь тусгайлан мэргэжих явдал байдаг ч мэдлэгийн салбарын ажилтнуудын хувьд мэргэжих асуудал нь харьцангуй чөлөөтэй хөрвөх боломжтой байдаг. Тэдний хувьд тухайн мэдлэгийн салбартаа л байвал нэг сургуулиас ч юмуу компаниас ч юмуу эсвэл бүр нэг улсаас нөгөө рүү шилжих нь юу ч бишгэж үздэг.

---

[1] Jeremy Rifkin, The End of Work: The Decline of the Global Labor Force and the Dawn of the Post-Market Era, (New York: JPPutnam, 1995), 223.

[2] Drucker, "Beyond the Information Revolution" in The Atlantic Online.

[3] Carol Ann Meares et al., The Digital Workforce: Building Infotech Skills at the Speed of Innovation (US Department of Commerce, June 1999), 21.

Мэдлэгийн нийгэм нь шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт байдаггүй хүний анхны нийгэм юм. Мэдлэгийг өвлүүлж эсвэл булааж авч болдоггүйгээрээ бусад бүтээгдэхүүнээс ялгардаг. Түүнийг хувь хүмүүс шинээр эзэмшиж болох ба хүн бүр нэг их анхаарал тавилгүй эхэлдэг.

Мэдлэгийн нийгмийн шилжилт хөдөлгөөнт байдлаас мэдлэгийг эцэс төгсгөлгүй өрсөлдөөн дунд, сэтгэл зүйн их тэвчээр зарж, өндөр зардлаар эзэмшдэг билээ. Энд хэрэв ялагдагчид гэж байдаг бол ялагч гэж бий. Энэ нь өмнөх нийгэмд байгаагүй билээ. Өөрийн эдлэн газаргүй тариачны хүү өөрөө эдлэн газаргүй ажилчин болоход тэрээр буруугүйд тооцогддог байсан. Харин мэдлэгийн нийгэмд тэрээр өөртөө төдийгүй нийгэмд ч буруутай.

Эх үүсвэр: “The Next Society: A Survey of the Near Future, “ The Economist (November 3, 2001), 8-11.

## Асрагчид гэж хэнбэ?

Эрэлт ихтэй байх бас нэг төрлийн ажил нь хүүхэд, хөгшид, тахир дутуу хүмүүс, сэтгэл санааны зовлон, дарамтанд өртсөд болон асаргаа сувилгаа шаардлагатай эрүүл мэнд тааруу хүмүүсийг төлбөртэйгээр асарч, халамжилдаг хүмүүс буюу *асрагчид* байх ажээ[4].

Хоёр шалтгаанаас асрагчдын тоо өдөр ирэх тутам нэмэгдсээр байна. Нэгдүгээрт, ажилдаа хэт анхаарал тавьж чөлөө завгүй ажилладаг хүмүүсийн тоо өсч байгаагаас тэд гэрийнхэндээ анхаарал тавих асуудлыг өөр хүнээр гэрээгээр гүйцэтгүүлэх болсон. Хоёрдугаарт, компьютер, техникийн туслалцаатайгаар удахгүй (аж үйлдвэрүүдэд компьютержсэн машин тоног төхөөрөмж, роботууд, үйлчилгээний салбарт банкны автомат машинууд, бензиний автомат түгээгүүрүүд, дуун автомат телефон утасны хариулагчид, бусад тоон төхөөрөмжүүд) бүгдийг хийж чаддаг болж болно. Бүгд гэдэгт хүмүүсийн хоорондын анхаарал халамжийг юугаар ч орлуулах боломжгүй тул орлуулан тооцох болохгүй юм. Дэвшилтэт технологийн улмаас ажилгүй болсон хэсэг хүмүүс анхаарал, халамжаа хүмүүст түгээж ингэснээр алдсанаж лаа орлуулж болох ажээ[5].

## Ирээдүйд фермер гэж байх уу?

Үйлдвэрлэлийн хувьсгал фермерүүдийг байхгүй болгоогүйтэй адил мэдээллийн хувьсгал ч тэднийг байхгүй болгож чадахгүй. Гэхдээ аж ахуйгаа эрхлэх аргачлал нь өөрчлөгдөнө. Тэд талбайнхаа аль ус шаардлагатай хэсгийг олж услах, бордоог илүү үр ашигтай ашиглах гэх мэт олон зүйлд мэдээллийг ашиглах болно. Мөн хөдөө аж ахуйн биотехнологи нь ургамлыг хувирган өөрчилж, хүнсний төрөл зүйл болгож тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх юм байна.

Ингэснээр арвин ургац авах төдийгүй тээврийн зардлаа хэмнэн холбоо харилцаагаар гүйлгээ хийх, фермийн бүтээгдэхүүнийг илүү үр дүнтэй борлуулж үнийг бууруулах, бараа бүтээгдэхүүнийг илүү сайн удирдах боломж бүрдэнэ.

## Бизнес эрхлэгчид? Шинэ зах зээлд тэд ямар үүрэгтэй вэ?

Интернэт нь бизнес эрхлэгчдэд тун таатай орчин болж өгдөг. Бизнес эрхлэгчид нь шинэ бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн шинэ арга нэвтрүүлж, шинэ зах зээл бий болгож байдаг. Бизнес эрхлэгчид нь интернэтийн шинэ нийгэмд давуу эрхийг эдэлнэ гэж Грегори К.Эриксэн үзэж байна. Тэрээр:

... Интернэтийн ертөнц нь бизнес эрхлэгчдэд яг тохирсон газар. Энэ нь аз турших эрмэлзлэл, ажилдаа зүрх сэтгэлээ зориулж чадах, цаг барьдаг, хурдан шуурхай үйл ажиллагаа явуулахыг шаардана. Интернэт нь технологи биш харин боломжийг бүрдүүлэгч юм. Энэ нь асуудлыг шийдвэрлэх болон бодит үр дүн авчрах, шинийг бүтээх суурь болдгоороо боломж бүрдүүлэгч болно. Өөрчлөлт авчрах санаануудыг аль болох хурдан хэрэгжүүлэх шаардлагатай байдаг[6].

## Бизнес эрхлэгчдийг хэрхэн дэмжих вэ?

Бизнес эрхлэгчид шинэ санаа аз туршилтыг дэмждэг, бүтэлгүйтэл нь бизнест байж болох зүйл хэмээн авч үздэг тийм л орчинд өсч хөгждөг. Бизнес эрхлэгчдийг бий болгох нь насан туршид суралцах орчинтой бас холбоотой. Насан туршид суралцах гэдгийг Европын Комисс “Хувь хүн, иргэн, нийгэм, ажил эрхлэлтийн хувьд өсч дээшилж, ажил эрхлэлтийн боломж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилгоор амьдралынхаа турш суралцаж байгаа бүх суралцах үйл ажиллагаа”[7] хэмээн тодорхойлжээ. Ийнхүү суралцан мэдээллийн эринтэй хөл нийлүүлэн алхахын тулд хүмүүс ур чадвар, сонирхол, мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж байх хэрэгтэй. Хэрвээ МХТ-ийг боловсролын салбарт зөв зохистой хэрэгжүүлж чадвал оюутан сурагчдыг 21 дүгээр зуунтай хөл нийлүүлэн насан туршид суралцахад нь тус дэм болох юм

### Жишээ 9. Бизнес эрхлэгчдийг сургах

Бизнес Эрхлэгчдийн Боловсролын Холбоо бизнес эрхлэлт нь доор хаяж 5-аас доошгүй боловсруулалтын үе шатаас бүрдэх насан туршдаа суралцах үйл ажиллагаа гэдэг зарчмыг дэмждэг. Уг насан туршдаа суралцах загвар нь манай боловсролын системд хүн бүр эхний үе

[4] Reich, The Future of Success, 176.

[5] Ibid., 176-7

[6] Gregory K. Ericksen, Net Entrepreneurs Only: 10 Entrepreneurs Tell The Stories of Their Success (New York, NY: John Wiley & Sons, 2000), ix.

[7] The European Commission, “Lifelong Learning,” European Communities, 1995-2002; http://europa.eu.int/comm/education/life/what_isIII_en.html; вэб хуудас, 2002 оны 8 сарын 31-нд хандсан.

шатуудад суралцаж болох боловч харин сүүлийн шатууд нь зөвхөн бизнес эрхлэгч болохоор сонгосон хүмүүст зориулагдсан байна.
Дараахь 5 үе шатууд нь тэдгээрийг бусад сургалтуудтай хавсран эсвэл дангаараа бие даасан хэлбэрээр сургалт болгон зохион байгуулж болно

Нэгдүгээр шат - ҮНДСЭН ШАТ

Бага, дунд, ахлах сургуулийн сурагчид бизнес эрхлэх талаар анхан шатны төсөөлөлтэй болох. Энэ нь эдийн засгийн талаар анхан шатны ойлголт өгөх төдийгүй чөлөөт эдийн засагт хэрхэн амжилттай ажил эрхлэх зэргийг заах үе шат. Насан туршдаа суралцах загварын энэ шатны гол зорилт нь цаашид суралцах чиглэл мэргэжил, өөрийн бололцоогоо тодорхойлоход оршино

Хоёрдугаар шат – ИТГЭЛ ҮНЭМШИЛ ЭЗЭМШИХ

Сурагчид бизнесийн хэлээр ярьж сурч, аливаа асуудалд жижиг бизнес эрхлэгчдийн байр сууринаас авч үзэн судлах болно. Энэ шатанд илүү мэргэжлийн сургалт хэрэгтэй болдог: Нэг хичээлийг бүтэн курсээр заах юмуу аль эсвэл өөр хичээлүүдэд агуулгын хувьд шингээн зааж болдог. Жишээ нь: бэлэн мөнгөний урсгал тухай математикийн хичээлээр, борлуулалтын тухай харилцааны хичээл дээр тус тус үзэж болох юм

Гуравдугаар шат – БҮТЭЭЛЧЭЭР АШИГЛАХ

Шинээр бизнес эрхлэх талаар суралцах их олон зүйл бий. Бид ганц эмч бэлтгэх гэж өчнөөн жил зарцуулдаг хирнээ жижиг бизнес эрхлэх гэсэн хүмүүсийг цөөхөн удаа семинарт суулгаад л болчихдог. Энэ үе шатыг ахлах сургуулийн мэргэжлийн хөтөлбөрүүдээр эсвэл тусгай курс болон тусгай мэргэжлийн диплом олгодог 2 жилийн коллеж болон зарим их, дээд сургуулиудад зааж зэрэг олгох хэрэгтэй. Ингэснээр оюутан, сурагчдын хувьд бизнес эрхлэгчид болох үүд хаалга аяндаа нээгдэнэ гэсэн үг.

Дөрөвдүгээр шат – БИЗНЕСИЙГ ЭХЛЭХ

Насанд хүрэгсэд дадлага туршлагатай, боловсролтой болсон хэдий ч бизнесийн санаагаа хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн туслалцаа шаардагдагдаж байдаг. Бизнесээ эхлэхэд хэрэгтэй сургалтыг дөрвөн жилийн сургалттай коллеж, их сургуулиудаар эзэмшиж болно

Тавдугаар шат – БИЗНЕСИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Ихэнх бизнес эрхлэгчид байдал хэцүү болж доройтох хүртэл ямар нэгэн туслалцаа авахыг хүсдэггүй. Харин цуврал семинар хичээл эсвэл зөвлөх бүлгүүд бизнес эрхлэгчид нарт тулгарсан асуудлуудыг ойлгуулах, түүнд дүн шинжилгээ хийж цаг алдалгүй шийдвэрлэхэд тусалж болох юм

Эх үүсвэр: Cathy Ashmore, “Five Stages of Lifelong Learning,” in The Consortium for Entrepreneurship Education [нүүр хуудас]; http://www.entre-ed.org/_entre/5-stages.htm; 2002 оны 8 сарын 29-нд хандсан